



**БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар XI/82

Булган сум

Г "Цахим Булган" хөтөлбөр Г
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ес дэх удаагийн сонгуулийн ээлжит XI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн технологи, цахим мэдээлэл солилцооны нэгдсэн системийг төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэн, түүнд суурилсан цахим үйлчилгээг хөгжүүлж, ил тод цахим засаглалыг бий болгож, иргэдэд түргэн шуурхай хялбар үйлчилгээг үзүүлэх зорилго бүхий "Цахим Булган" хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган бусад төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай уялдуулан шийдвэрлэж, тайлан мэдээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Пүрэв-Очир)-д даалгасугай.

4.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд чанартай шуурхай зохион байгуулан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, төр, хувийн хэвшлийн оролцоо, идэвх, санаачилгыг дэмжин хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрх зүй, ёс зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо (А.Сод-Эрдэнэ)-нд даалгасугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

6325010053



БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар VI/33

Булган сум

Г "Англи хэлтэй Булган" хөтөлбөр Г
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, Боловсролын Ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы Сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжин ерөнхий боловсролын сургуулийн "Багш", "Сурагч", "Оюутан" төрийн албан хаагч, иргэдийн англи хэлний ярих, сонсох, унших, бичих чадварыг ахисан түвшинд гаргах боломжийг бүрдүүлэх зорилгоор "Англи хэлтэй Булган" хөтөлбөрийг баталсугай.

2. "Англи хэлтэй Булган" хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг 2 дугаар, хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган бусад төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай уялдуулан шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Пүрэв-Очир)-д даалгасугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн оролцоог ханган, нийгмийн байгууллагуудын идэвх, санаачилгыг дэмжин хамтран ажиллаж, зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан мэдээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн

6325010009

Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

5.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд чанартай шуурхай зохион байгуулан мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын газар (Ц.Цолмонбаатар)-т үүрэг болгосугай.

6.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (О.Наранжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Ш.НАСАНДУЛАМ

